



ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 01

Улаанбаатар

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛЖ, ОЛГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь заалт, Тахько (ХК) компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2018 оны цэвэр ашгаас тус компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 108 төгрөгөөр тогтоож, 2018 оны цэвэр ашгаас 128,518,164 төгрөг хуваарилж, хүн амын орлогын албан татварыг холбогдох хууль тогтоомжийн дагуу суутгасан дүнгээр 2019 оны 5 дугаар сарын 01-ний дотор мөнгөн хэлбэрээр олгосугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй тус компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг компанийн 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Ногдол ашиг хуваарилж, олгох шийдвэрийн тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хуваарилсан ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ХХ) компанитай гэрээ байгуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар тарааж олгохыг Гүйцэтгэх захирал (Л.Энхнасан)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ



ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 02

Улаанбаатар

ХУВЬЦАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.4 дэх заалт, Тахько (ХК) компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.10 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигч Сэдхүү овогтой Дамдиндоо (Регистр ВД63050531) нь өөрийн эзэмшлийн 2,100 ширхэг энгийн хувьцааг компанид эргүүлэн худалдах тухай хүсэлт ирүүлснийг хүлээн авч нэгж хувьцааны үнийг 12,200 төгрөг байхаар харилцан тохиролцсоныг үндэслэн нийт 2,100 ширхэг энгийн хувьцааг эргүүлэн худалдаж авах, халаасны хувьцаагаар бүртгэх, нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал (Л.Энхнасан)-д зөвшөөрсүгэй.
2. Хувьцаа эзэмшигч С.Дамдиндоогийн эзэмшлийн 2,100 ширхэг энгийн хувьцааг нийт 25,620,000 төгрөгөөр худалдан авах гэрээг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагатай байгуулан холбогдох хууль тогтоомжийн дагуу 2019 оны 2 дугаар сарын 25-ны дотор худалдан авахыг Гүйцэтгэх захирал (Л.Энхнасан), ерөнхий нягтлан бодогч (Б.Сольрагчаа) нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ